



ГОВЬ ХУВЬЦААТ КОМПАНИ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4-р сарын 29-ний өдрийн 10:00 цагт СБД, 3-р хороонд байрлах Хаан Банкны Сөүл оффисын Хаан театрт боллоо. Хурлыг Говь ХК-ийн ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа даргалж, ТУЗ-ийн хараат бус гишүүн А.Жаргалмаа, Тэргүүн дэд захирал Б.Ариунаа, Тэргүүн дэд захирал Б.Энхмандах, Кэй Пи Эм Жи Аудит ХХК-ийн Ахлах аудитор Д.Чинболд нар оролцов.

ХУРЛЫН НЭЭЛТ

Хөтлөгч 3.Отгонжаргал: Сайн байцгаана уу? Говь ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал – 2024 эхлэхэд бэлэн боллоо. Хурлын ирцийг хурлын даргад танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга, хатагтай Н.Сайнзул таныг тайзнаа урьж байна.

1. ХУРЛЫН ИРЦИЙГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул бүртгэлийн өдөр 2024 оны 4-р сарын 10-ны өдөр байсныг дурдаж, Говь ХК-ийн нийт саналын эрхтэй хувьцааны тоо 780,112,500 байгаагаас хурлын материалтай урьдчилан танилцан санал өгөх арга хэлбэрээр 12,462,706 буюу 1.60% саналын эрхтэй 629 хувьцаа эзэмшигч, өнөөдрийн хуралд биечлэн оролцох арга хэлбэрээр 678,761,381 буюу 87.01% саналын эрхтэй 74 хувьцаа эзэмшигч оролцсоноор нийт хурлын ирц 88.61% болсон тухай хурлын даргад мэдэгдэж, хурлын ирц бүрдэж Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтад заасан шаардлагыг хангасныг танилцуулав.

Хөтлөгч 3.Отгонжаргал: Хурлын ирцийг танилцуулсан хатагтай Н.Сайнзул танд баярлалаа. Ийнхүү хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулна уу хэмээн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Гэрэлмаа таныг урьж байна.

2. ХУРЛЫН ДЭГИЙГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ энэ өглөөний амар амгаланг айлтгая. Хурлын ирц хангалттай байгаа учир Говь ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэхэд бэлэн болоод байна. Говь ХК нь 2023 оныхоо санхүү болон үйл ажиллагааныхаа үр дүнг та бүхэнд танилцуулахад бэлэн болоод байна. Хурлын дэг болон хуралд ирсэн хүмүүсээ танилцуулъя. ТУЗ-ийн хараат бус гишүүн, олон улсын мэргэшсэн нягтлан бодогч А.Жаргалмаа, Тэргүүн дэд захирал Б.Ариунаа, Тэргүүн дэд захирал Б.Энхмандах, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ, мөн миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Гэрэлмаа нар өнөөдрийн тайлангаа тавихад бэлэн болоод байна. Та бүхэндээ хэлэлцэх асуудлуудаа дарааллаар нь танилцуулъя:

1. Компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүү үр дүнгийн тайланг танилцуулах
2. 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулах
3. ТУЗ-өөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах
4. ТУЗ-ийн 2023 оны ажлын тайланг танилцуулах
5. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төсөл
6. ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсвийг танилцуулах
7. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулах байгаа.

Хурлын үргэлжлэх хугацааг 2 цаг гэж төлөвлөсөн байгаа. Хурлын бэлтгэл ажлын хүрээнд та бүхэнд хурлын материалуудыг тараан өгсөн. Хурлын материалтай танилцаж амжаагүй хүмүүс байвал зохион байгуулагчдаас аваад танилцах боломжтой.

Хөтлөгч 3.Отгонжаргал: ТУЗ-ийн дарга, хатагтай Д.Гэрэлмаа танд маш их баярлалаа. Тооллогын комиссыг томилсон тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулна уу хэмээн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ таныг урьж байна.

3. ТООЛЛОГЫН КОМИССЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Хүрэлцэн ирсэн хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өглөөний мэндийг хүргэе. Говь ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны 3-р сарын 20-ны №13 тоот тогтоолоор энэ жилийн Тооллогын комиссыг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон байгаа. Та бүхэнд бүрэлдэхүүнийг танилцуулъя. Тооллогын комиссын даргаар Дотоод аудитын хэлтсийн ахлах аудитор Н.Сайнзул, нарийн бичгийн даргаар Үйлдвэр бүртгэлийн албаны дарга Ц.Цэцэгбадам, гишүүдээр Хүний нөөцийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Уянга, Аудитор Д.Сарангуа, Нягтлан бодогч Б.Ууганзаяа, Нягтлан бодогч Б.Номин гэсэн 6 хүний бүрэлдэхүүнтэй тооллогын комисс томилогдон ажиллаж байна. Эдгээр хүмүүс маань өнөөдрийн хэлэлцэж буй асуудалтай ямар нэгэн холбоогүй бөгөөд компанийн эрх бүхий албан тушаалтан биш байгаа гэдгийг онцолж хэлмээр байна. Тооллогын комиссын гишүүд маань та бүхний зүүн гар талд сууж байна. Баярлалаа.

Хөтлөгч 3.Отгонжаргал: Ингээд хэлэлцэх асуудлуудтайгаа танилцъя.

4. ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

4.1 Компанийн 2023 оны үйл ажиллагааны үр дүнг танилцуулах /1-р хэсэг/

/2023 оны үйл ажиллагааны үр дүнгийн талаарх 5 минутын видеог хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нарт үзүүлэв./

Хөтлөгч 3.Отгонжаргал: Говь ХК-ийн 2023 оны санхүүгийн үр дүн болон 2024 оны зорилтыг танилцуулна уу хэмээн Тэргүүн дэд захирал, хатагтай Б.Ариунааг урьж байна.

4.1 Компанийн 2023 оны санхүү үр дүн болон 2024 оны зорилтыг танилцуулах /2-р хэсэг/

Тэргүүн дэд захирал Б.Ариунаа танилцуулав.

Тэргүүн дэд захирал Б.Ариунаа: Сайн байцгаана уу. Өнөөдрийн хуралд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэдээ энэ өдрийн мэндийг хүргэе. Та бүхэн 2023 оны үйл ажиллагааны онцлох үйл явдлуудын тайлантай видео хэлбэрээр танилцлаа. Үргэлжлүүлээд 2023 оны санхүүгийн үр дүнг 2022 онтой харьцуулсан байдлаар болон 2024 онд бидний зорьж буй төлөвлөгөөтэй танилцана уу.

Говь ХК-ийн 2023 оны цэвэр борлуулалтын хувьд 255 тэрбум байсан нь өмнөх жилээс 31 хувийн өсөлтийг үзүүлсэн. 2024 онд 8 хувийн өсөлттэй буюу 275 тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөж байна. 2023 оны цэвэр борлуулалтыг борлуулалтын үндсэн 3 суваг болох дотоод борлуулалт, экспортын борлуулалт болон гадаад борлуулалтаар задалж харвал: Дотоод борлуулалт нь 147 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 182 тэрбум төгрөг болж 24 хувийн өсөлттэй байх төлөвлөгөөтэй, Экспортын борлуулалтын хувьд 59 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 66 тэрбум төгрөг болж 12 хувийн өсөлттэй байхыг зорьж байна, Гадаад борлуулалтын хувьд 49 тэрбум төгрөг байсан бол 2024 онд 66 тэрбум төгрөг болж 45 хувиар бууруулахаар төлөвлөж байна.

Борлуулсан бүтээгдэхүүний тоо ширхгийн хувьд 2023 онд бид 1,146,000 ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнө жилээс 15 хувийн өсөлт үзүүлсэн бол бид 2024 онд тоо ширхгийн хувьд 7 хувийн өсөлт үзүүлж 1,225,000 ширхэг бүтээгдэхүүн борлуулахыг зорьж байна. Борлуулсан бүтээгдэхүүнүүдийн тоо ширхгийг дараагийн хуудсууд дээр илүү дэлгэрэнгүй танилцуулна.

Борлуулсан бүтээгдэхүүний дундаж үнийн хувьд 223,000 төгрөг байсан нь өмнө жилийнхтэй харьцуулбал 14 хувийн өсөлттэй байсан. 2024 онд бид үүнийг харьцангуй тогтвортой барьж 224,000 төгрөг байх зорилт дэвшүүлээд байна.

Цэвэр ашгийн хувьд бид 6.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан. Энэ нь өмнөх жилтэй харьцуулбал 3 хувиар сайжирсан үзүүлэлт байгаа. Харин 2024 оны хувьд бид 12.6 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж 286 хувийн өсөлт гаргахыг зорьж байна.

Борлуулалтын үндсэн сувгуудыг илүү дэлгэрэнгүй тайлбарлая.

- **Дотоод борлуулалтын хувьд**, бид 2023 онд тоо ширхгийн хувьд 640,475 ширхэг бүтээгдэхүүн борлуулсан нь өмнөх онтой харьцуулахад 36 хувийн өсөлттэй байсан. 2024 онд бид 750,000 ширхгийг борлуулахыг зорьж байна. Дотоодын борлуулалтын хувьд жуулчдын борлуулалт маш чухал байдаг. 2023 онд Монгол Улсын Засгийн Газраас аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлж бүтэн жилийн туршид WELCOME TO MONGOLIA хөтөлбөр аяныг зохион байгуулсан. Энэ аяны хүрээнд үр дүн маш сайн гарч 2022 онд 286 мянган жуулчин ирж байсан бол энэ тоо 2023 онд 650 мянгад хүрсэн эерэг өөрчлөлт гарсан. 2024 онд Засгийн газраас энэ бодлогоо GO MONGOLIA болгон өргөжүүлж 1,000,000 жуулчдыг Монгол Улсад татах бодлого барьж ажиллаж байна. Борлуулалтын бүтцийн хувьд 2022 онд дотоодын нийт борлуулалтын 20 хувийг жуулчдын борлуулалт эзэлж байсан нь 2023 онд 52 хувь болж өссөн. 2024 онд бид борлуулалтын 55 хувийг жуулчдын борлуулалт эзэлнэ гэж төлөвлөж байна.
- **Экспортын бөөний борлуулалтын хувьд**, бид 2021 оноос эхлэн бодлогын хувьд өөрчлөлт хийж илүү стратегийн буюу урт хугацааны түншүүдтэй хамтарч ажиллан, илүү масстай захиалгууд авснаараа үйлдвэрт илүү бүтээмжтэй байж, нөгөө талаар компанийн ашигт ажиллагааг нэмэх бодлогыг барьж ажиллаж байна. 2023 оны хувьд 51 харилцагчид 351,768 ширхэг бүтээгдэхүүнийг цаг хугацаанд нийлүүлэн ажиллаа. 2024 оны хувьд 420,000 ширхэг болгон тоо ширхгийн хувьд 19 хувийн өсөлттэй байхаар төлөвлөж байна. Мөн харилцагчийн тоог 51-ээс 60 хүргэхээр зорьж байна.
- **Гадаад борлуулалтын хувьд**, та бүхний мэдэж байгаачлан Говь ХК 2019 оноос бодлогын чухал шийдвэрийг гарган олон улсын зах зээл дээр жижиглэнгээр бүтээгдэхүүнээ хүргэх нь урт хугацаандаа бидэнд маш хэрэгтэй байна гэж үзсэн тул энэ чиглэл рүү орж ажиллаж эхэлсэн. Дөнгөж ажиллаж эхлэх үед дэлхий нийтийг хамарсан цар тахал гарсан. Тэгэхээр өнгөрсөн 4 жилийн хугацаанд бид маш хязгаарлагдмал нөхцөл байдалд, алдаа оноотой олон ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Одоо бидний дүгнэж буйгаар эхний 4 жил бол бидний олон улсад нэвтрэх нэвтрэлтийн үе шат байлаа. Энэ үеийг бид харьцангуй амжилттай давж туулсан гэж үзэж байна. Олон улсын зах зээлд олон зуун жилийн түүхтэй дэлхийд

танигдсан брэндүүдтэй өрсөлдөхийн тулд бид маркетингийн зардал дээр нэлээдгүй хөрөнгө оруулалтыг хийсэн. Үүний үр дүнд 2022 онд манай бүртгэлтэй харилцагчдын тоо 382 мянга байсан бол 2023 онд 597 мянга болж өссөн. Танигдалтын үе шат хангалттай сайн хийгдсэн гэж бид үзэж байгаа тул 2024 оноос бид зах зээл дээр эзэлж буй байр сууриа бэхжүүлэхийн төлөө тооноос илүү чанарт анхаарах бодлогыг барьж ажиллаж байна. Өнгөрөгч 2023 онд бид 25.9 тэрбум төгрөгийг маркетингийн зардалд зарцуулж байсан бол 2024 оноос маркетингийн зардлаа 9.2 тэрбум болгон бууруулж байгаа, мөн хэрэглэгчдийг илүү татах зорилгоор жилийн турш бараа бүтээгдэхүүнээ тодорхой хямдралтай үнээр санал болгодог байсан бөгөөд энэ хямдралын дундаж хувь 53-55 хувьтай байсныг 30 орчим хувь руу бууруулснаар нэгжийн борлуулах үнэ маань 93 ам.доллараас 139 ам.доллар болж өсч компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэх бодлогыг баримталж байна.

Мөн өнгөрсөн 4 жилийн хугацаанд хязгаарлагдмал орчинд ажиллаж байсан тул бид дан онлайн төвтэй ажиллаж байсан бол одоо бид онлайн дэлгүүртэй хослуулсан хэлбэрээр гадаад зах зээл рүү гарах нь урт хугацаандаа илүү зөв юм байна гэж үзсэн. Үүний эхлэл болгон 2023 оны 10-р сард ХБНГУ-ын Дюссельдорф хотноо 2 дахь албан ёсны салбар дэлгүүрээ нээсэн. Цаашид ч бид дэлгүүрүүдээ нээхдээ зөвхөн салбар дэлгүүр нээхгүйгээр тухайн зах зээлээ илүү мэдэж байгаа, зах зээлээ илүү сайн ойлгодог компаниудтай хамтарч ажиллан франчайзинг эрх олгох замаар дэлхийн олон улс, хотуудад Говь брэндийн дэлгүүрийн тоог нэмэгдүүлэх бодлоготой ажиллаж байна.

Энэ бодлогын хүрээнд бид Европын холбоо, АНУ, БНХАУ, Их Британи гэсэн үндсэн 4 зах зээлд төвлөрч 55 мянган ширхэг бүтээгдэхүүн борлуулж, нийт 27.3 тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөж байна.

Үйлдвэрлэлийн хувьд, бид 2022 оноос 23 хувийн өсөлт үзүүлсэн буюу 2023 онд 1,040,000 ширхэг үйлдвэрлэсэн бөгөөд 2024 онд үйлдвэрлэлийн тоо ширхэг дээр харьцангуй тогтвортой барьж 1,004,000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр зорьж байна.

Бүтээгдэхүүний үндсэн 3 нэр төрөл буюу сүлжмэл, нэхмэл ба оёмол бүтээгдэхүүнийг тоо ширхгээр задлан үзвэл:

- Сүлжмэл ба оёмол бүтээгдэхүүний тоо ширхгийн хувьд харьцангуй тогтвортой буюу бага хувиар өссөн.
- Нэхмэл бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэл нь 264,000 ширхэг болж 2022 онтой харьцуулахад 94 хувийн өсөлт үзүүлсэн. 2024 онд мөн 17 хувиар өсөж 310,000 ширхгийг үйлдвэрлэхээр зорьж байгаа. Нэхмэл бүтээгдэхүүний хувьд яагаад ингэж өсгөж байгаа вэ гэвэл жуулчдын борлуулалттай холбоотой. Учир нь Монгол Улсад ирж буй жуулчдын дийлэнх хувийг БНСУ-ын жуулчид эзэлдэг. Тэр дундаа 2023 онд Говь ХК-аас худалдан авалт хийсэн жуулчдын 75 хувь нь БНСУ-ын жуулчид байсан. Өмнөд Солонгосын хэрэглэгчдийн хувьд ороолт зүүх соёл маш их дэлгэрсэн тул бэлгэнд хамгийн их худалдан авдаг бүтээгдэхүүн нь нэхмэл ороолт байдаг. Үүнтэй холбоотойгоор нэхмэл бүтээгдэхүүний үйлдвэрлэл дагаад өссөн үзүүлэлттэй байна.

Бид Говь ХК нь хөгжлийн дараагийн үе шат руугаа орж байна хэмээн үзэж байгаа. Та бүхэнд танилцуулсан дээрх зорилтууддаа хүрэхийн тулд бид дараах үндсэн стратегийн чиг үүргүүдийн хүрээнд олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлж байна.

Бүтээгдэхүүний загвар болон чанар, бид гадаадын зах зээл дээр харилцан хоорондоо адилгүй ялгаралтай зах зээлүүд дээр ажиллаж байгаа. Иймд бараа бүтээгдэхүүний загвар болон бүтээгдэхүүний чанартаа анхаарахаар Италийн алдарт дизайнер Жиоржио Спинатай хамтран ажиллаж байгаа бөгөөд тус хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэхээр байгаа. Бид мөн хэрэглэгчдэдээ инновац шингэсэн бүтээгдэхүүн хүргэхийн хүрээнд жил бүр судалгааны ажлууд хийж байдаг. 2023 онд бид цоо шинээр зах зээлд ноолууран гутал болон ноолууран

малгайг танилцуулсан байгаа. Мөн ээрмэл болон сүлжмэлийн үйлдвэрүүд дээр чанар, бүтээмжийг сайжруулах судалгааны ажлууд хийгдээд явж байна.

Маркетинг ба контент, олон улсын зах зээл дээр өрсөлдөж буй манай компанийн хувьд брэндийн ялгарал онцлог болон олон улсын хэрэглэгч нар яагаад Говь брэндийг сонгох ёстой вэ гэдэг онцлог байдлаа бид маш ойлгомжтойгоор хүргэх нь чухал байдаг. Энэ хүрээнд бид компанийн хэмжээнд rebranding төсөл эхлүүлэн явж байна. Манай компанийн лого, бэлгэ тэмдэг, хэрэглэгчдэдээ хүргэдэг мессэж зэрэг нь иж бүрэн шинэчлэгдэж 2024 оны 2-р хагасаас шинэчлэгдсэн өнгө төрхтэйгөөр хэрэглэгчдэдээ хүрэхээр төлөвлөж байгаа.

Үргэлжлүүлээд бид хэрэглэгчдэдээ сонголтыг ойлгомжтой байлгах үүднээс коллекцуудын маркетинг болон дэлгүүрүүд дээр хийгдэж буй бараа бүтээгдэхүүний өрөлт, хураалтыг цогц байлгах олон ажлуудыг төлөвлөөд хийж байна. Мөн Монгол Улсад зочлох жуулчдын заавал зочлох газруудын нэгээр бид Говь ХК-ийн үйлдвэр болон дэлгүүр байгаасай гэж зорьж ажиллаж байгаа. Энэ тал дээр бид оролцогч талууд болох хувьцаа эзэмшигчид, малчид, цаашлаад ажил мэргэжлийн гараагаа эхлэхээр зэхэж буй шинэ төгсөгчдөд Говь ХК-ийн үйлдвэртэй танилцах боломжийг нээлттэй олгож байгаа. Энэхүү Gobi experience төсөл маань цаашдаа үргэлжлэх болно.

Борлуулалт, төв дэлгүүрийн шинэчлэлийг хийн 5-р сард ашиглалтад оруулахаас гадна худалдааны зөвлөхүүдийн хүртээмж, ур чадварыг сайжруулахад анхаарч, үнэнч хэрэглэгчийн урамшуулалт хөтөлбөрийг хэрэгжүүлэн, Франчайзийн бодлого нөхцөлүүд болон эко системийг улам сайжруулахаар төлөвлөж байна.

Үйл ажиллагаа болон процессын автоматжуулалт, компанийн үйл ажиллагааг автоматжуулах болон процессыг сайжруулах хүрээнд хийгдэж буй хамгийн том төсөл бол ERP системийн нэвтрүүлэлт байгаа. Өнгөрсөн 9 сарын хугацаанд тусдаа төслийн баг гарч нийт Говь ХК-ийн хамт олон тэр чигээрээ SAP-ERP төсөл дээр ажилласны үр дүнд бид ердөө хоёр хоногийн дараа компани даяараа системийн нэвтрэлтийг хийхээр зорин ажиллаж байна.

Тогтвортой хөгжил, олон улсын зах зээл дээр өрсөлдөж буй Говь брэндийн хувьд бараа бүтээгдэхүүн чанартай, үнэ өрсөлдөхүйц байхаас гадна тогтвортой бизнесийн загвар өнөө үед маш эрчимтэй яригдаж буй тул үйлдвэрлэл явуулахдаа байгаль орчиндоо хэр ээлтэй байгаа талаар, мөн хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг бууруулахаар ямар ажлууд хийж байгаа талаар оролцогч талууд улам илүү анхаарлаа хандуулах болсон.

Өнгөрсөн жилүүдэд компани хэдийгээр санхүүгийн хувьд харьцангуй хүндрэлтэй нөхцөлд ажиллаж байсан боловч байгаль орчны хүрээнд хийгдэж буй ажлуудыг шат дараатай хийсээр ирсэн. Бид өмнө нь зөвхөн ээрмэл утсан дээрээ авдаг байсан бол 2024 оны хувьд илүү олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бэлэн бүтээгдэхүүний OEKO TEX гэрчилгээг авах, цаашлаад дэлхийн органик бүтээгдэхүүний батламж болох GOTS гэрчилгээг авах бэлтгэл ажлуудаа ханган ажиллаж байна. Мөн үйлдвэрлэлийнхээ тодорхой хэмжээний цахилгааны хэрэглээг зохистой байлгах үүднээс нарны эрчим хүчний эх үүсвэрийг ашиглаж эхлэх судалгааны ажлуудыг хийж байна. Усны хэрэглээг зохистой түвшинд байлгах болон саарал усны ашиглалтыг нэмэгдүүлэх хүрээнд цэвэрлэх байгууламжаа сайжруулах зэрэг ажлуудыг төлөвлөж байна.

Байгууллагын соёл ба ажилтны ур чадвар, Монгол Улсын хувьд ажиллах хүчний хомсдол мөн тулгамдаж буй асуудлуудын нэг болоод буйг та бүхэн мөн мэдэж байгаа. Тэр тусмаа үйлдвэрлэлийн салбарт энэ асуудал нь нэлээд тулгамдаж байгаа. Энэхүү асуудал дээр бид дотроо хэлэлцэж зөвлөлдсөний хүрээнд өөрсдийн нөөц бололцоог ханган ГОВЬ академи хөтөлбөрийг хэрэгжүүлж гэж шийдсэн. Тус хөтөлбөрийн хүрээнд бид мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдтэй хамтран нарийн мэргэжлийн буюу бидэнд шаардлагатай байгаа

чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэх, төгсөж буй сурагч залууст мэргэжлийн үнэмлэх олгох, суралцаж буй явцад Говь ХК-д дадлага хийх боломжийг олгох болон төгсөгчдийг 100% ажлын байраар хангах зэрэг ажлуудыг хийж байна.

Мөн компанийн өөрийн дотоод бололцоогоо ашиглан дотооддоо сургагч багш нарыг бэлтгэн, тэднээр дамжин нарийн мэргэжлийн залгамж халаагаа бэлдэх ажлуудыг хийж байна. Компанийн хувьд хамгийн үнэтэй баялаг бол хүн. Тиймээс бидний хувьд ажилтнууд маань тасралтгүй өсч хөгжих бололцоогоор хангагдаж, дэлхийд өрсөлдөхүйц цалин авах болон ажлын байр ба ажиллах орчин нь тав тухтай байх зэрэг ажилтнаа дэмжих хөтөлбөрүүд дээр сүүлийн жилүүдэд ихээхэн анхаарч олон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Цаашдаа ч энэ хүрээнд олон томоохон хэмжээний ажлуудыг хийнэ гэж төлөвлөж байна.

Та бүхэнд танилцуулсан тоон зорилтууд, тэдгээрийг дэмжих бодлогын ажлуудыг хэрэгжүүлэхэд бидэнд аз жаргалтай, сэтгэл ханамжтай ажилтнууд маш чухал. Түүнчлэн манай компанийн оролцогч талууд буюу бидэнд түүхий эд бэлтгэн нийлүүлдэг малчид, манай хэрэглэгч харилцагчид, хувьцаа эзэмшигчид зэрэг бүх талуудын оролцоог хангаж, илүү ил тод, нээлттэй ажилласнаар бид илүү тогтвортой хөгжиж, хүн төвтэй компани болж дэлхийд танигдсан Монгол брэнд болох их үйлсэд манай компанийн нийт хамт олон урам зориг, итгэл дүүрэн ажиллаж байна.

Та бүхэнд биднийг дэмжин ажилладагт маш их баярлалаа. Мөн анхаарал хандуулсанд баярлалаа.

Хөтлөгч 3.Отгонжаргал: Говь ХК-ийн 2023 оны санхүүгийн үр дүн болон 2024 оны зорилтыг танилцуулсан Тэргүүн дэд захирал, хатагтай Б.Ариунаа танд маш их баярлалаа.

Ингээд 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй тухай үндэслэлийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ таныг урьж байна.

4.2 Ногдол ашиг хуваарилахгүй тухай тогтоолыг танилцуулах

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Та бүхэнд би Говь ХК-ийн 2023 оны санхүүгийн үр дүнгээс ногдол ашиг хуваарилахгүй болсон тухай шийдвэрийн үндэслэлийг албан ёсоор танилцуулъя.

Говь ХК-ийн ТУЗ-ийн зүгээс 2018 онд Ногдол ашгийн журмыг баталсан байдаг. Энэхүү журмын 2-р бүлэгт Ногдол ашгийн бодлогоо тодорхойлсон бөгөөд тус бодлогын 2.3-т манай компани ямар нөхцөлд ногдол ашиг хуваарилахыг заасан байгаа. Энэхүү нөхцөлийг та бүхэнд танилцуулбал, компани нь Компанийн тухай хуулийн 47-р зүйл, компанийн дүрмийн 8.12-т заасан ногдол ашиг хуваарилах нөхцөл хангагдсан нөхцөлд ногдол ашгийг хуваарилна гэж тодорхойлсон. Өөрөөр хэлбэл хамгийн эхлээд ногдол ашиг төлсний дараа компани төлбөрийн чадвартай байх, мөн ногдол ашиг төлсний дараа компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь Компанийн тухай хуулийн 30.5-т заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх гэсэн үндсэн нөхцөлүүд байдаг. Эдгээр нөхцөлүүдийг харгалзан үзээд ТУЗ-ийн 2024 оны 1-р сарын 26-ны өдрийн хурлаар компанийн 2023 оны санхүүгийн үр дүнг хэлэлцээд компанийн ногдол ашгийн бодлогын 2.3-т заасан ногдол ашиг олгох нөхцөлийн алийг нь ч хангаагүй буюу санхүүгийн зохистой харьцааг хангахгүй байгаа тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Баярлалаа.

Хөтлөгч 3.Отгонжаргал: Маш их баярлалаа. ТУЗ-өөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн дарга, хатагтай Д.Гэрэлмаа таныг урья.

**4.3 ТУЗ-өөс компанийн 2023 оны үйл ажиллагаа болон санхүүгийн
тайлангийн талаар гаргасан дүгнэлтийг танилцуулах**
ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Ариунаа захирал болон нарийн бичгийн дарга Сэлэнгэ нарт талархал илэрхийлье. Миний хэсэг бол компанийн Гүйцэтгэх удирдлагын багийн санхүүгийн үр дүн болон үйл ажиллагааны жилийн тайланд өгч буй ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулах чухал, хариуцлагатай үүрэг над дээр оногддог байгаа. Монгол Улсын Компанийн тухай хууль, Говь ХК-ийн дүрмийн хүрээнд 2023 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн үр дүнг 2024 оны 1 сарын 26-ны өдрийн ТУЗ-ийн хурлаар бид хэлэлцээд өнөөдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар танилцуулж байгаа. Ер нь үйл явцын хувьд 2024 оны эхний ТУЗ-ийн хурлаар бид бизнес төлөвлөгөөний үндсэн зорилтууд, үйл ажиллагааны ерөнхий чиглэлээ батлахад ТУЗ нь Гүйцэтгэх удирдлагын багийг ерөнхийд нь чиглүүлэх, хяналт тавих байдлаар хамтарч ажиллаж байгаа. Үүний хүрээнд Гүйцэтгэх удирдлагын баг нь тодорхой хэмжээний санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг аваад энэхүү гүйцэтгэлийг гаргасан гэж үзэж байна. Нөхцөл байдал сүүлийн хэдэн жил санхүүгийн тал дээр бол сайн байгаагүй буюу алдагдалтай ажиллаж байсан хэдий ч бид үндсэн үйл ажиллагаа болон ирээдүйгээ огт хаяагүй, дандаа ирээдүйгээ бодож ажиллаж ирсэн. Өнгөрсөн жилийн ерөнхий бизнес төлөвлөгөөний зорилтын биелэлтийг харахад Говь ХК-ийн амжилтыг 2 тоон үзүүлэлт дээрээс харж болно гэж үзэж байна.

Үүнд, борлуулалтын орлого 255 тэрбум төгрөгт хүрсэн ба нөгөө талаар бид 1,000,000 ширхэг бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг боллоо. Энэ нь манай Гүйцэтгэх удирдлагын баг болон үүний ард ажиллаж буй бүх баялаг бүтээгч ажилтнуудын маш их чармайлт, хичээл зүтгэлийн үр дүн гэдгийг бас дурдах нь зүйтэй гэж бодож байна.

Нөгөө талаар бид олон улсын тавцан дээр гарч үйл ажиллагаагаа эхлүүлсэн тул бидэнд ухрах зам огт байхгүй, тасралтгүй маркетингийн зардлаа гаргаж үүнийхээ хойноос маш чамбай ажиллах шаардлага зайлшгүй гарч байгаа учраас Ариунаа захирлын танилцуулгад дурдагдсан ERP систем зэрэг цахимжих үйл явцыг бид нэлээдгүй бодож, хэрэгжилтийг нь хангахад нэлээдгүй цаг, хүч хөдөлмөр зарцууллаа. Одоо ч бас манай хамт олон байдаг чадлаараа л хичээж байгаа гэж ойлгож байгаа. Ер нь ERP системийг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах, өөрсдийн шийдвэр гаргалтыг дандаа зах зээлийн тооцоо судалгаа дээр үндэслэн, оновчтой зөв шийдвэрүүд гаргах боломж их ойрхон болж байна гэж харж байна.

Үүний зэрэгцээ олон улсын тавцан дээр үйл ажиллагаа явуулж буй компанийн хувьд хамгийн чухал шаардлага юу байдаг вэ гэвэл ямар гарал үүсэлтэй бүтээгдэхүүнээр, ямар боловсруулалт хийж байгаа, энэ нь дэлхий ертөнцийн өнөөгийн нөөцийн хомсдол, байгаль орчны доройтол, нийгмийн тэгш бус байдлыг бууруулахад компани өөрөө ямар үүрэгтэй байгаа вэ гэдэг нь олон оролцогч талуудын сонирхлыг татдаг асуудал болсон байна. Энэ хүрээнд Говь ХК байгаль орчин, нийгэм, засаглалын асуудлууд дээр сүүлийн 2 жилд тасралтгүй ажиллаж, өнгөрсөн жил чамгүй олон амжилтуудыг гаргалаа. Үүнд бидний хэрэгжүүлж буй гурван талт хамтарсан Тогтвортой ноолуур төсөл маань шилдэг нийгмийн хариуцлагатай төслөөр шалгарлаа. Нөгөө талдаа бид Азийн хөгжлийн банкны санхүүжилтийг авах боломжийг олж авлаа. Тогтвортой, нөөцийн зохистой хэрэглээтэй, урт хугацаанд тасралтгүй аваад явах тогтолцоог бүрдүүлсэн буюу сууриа сайн тавьсан гэдэг нь үүнээс харагдаж байна.

Мөн та бүхний анхаарлыг хандуулмаар байгаа бас нэгэн асуудал бол хүний нөөцийн асуудал байгаа. Баялаг бүтээж буй салбарт, өөрсдөө малын гаралтай түүхий эдээ боловсруулаад дэлхийд танигдсан брэндийг бүтээх нэлээдгүй нүсэр ажлын ард дандаа манай ажилтнууд явж байдаг. Гэтэл хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэгдэж буй хүний тоо сүүлийн жилүүдэд бол хангалтгүй байгааг та бүхэн мэдэж байгаа. Иймд бид хүний нөөцийн бодлогоороо ба байгууллагын соёлоороо аз жаргалтай ажилтан хөтөлбөр болон хүний нөөцөө өөрсдөө сургаж авахгүй бол бэлэн хүний нөөц авах боломжгүй болсонтой холбоотойгоор ажилтнуудаа тогтвор

суурьшилтай ажиллуулах, ажилтнуудын цалин болон ажлын орчин сайжруулах ажлуудад сүүлийн 2 жилд тасралтгүй, уйгагүй ажлууд хийгдэж буйг онцлон тэмдэглэмээр байна.

Эцэст нь, үүссэн нөхцөл байдал, өөрт буй боломжийг чадлынхаа хэмжээнд тултал нь ашиглалаа гэж ТУЗ-өөс Гүйцэтгэх удирдлагын багийг дүгнэсэн. Урд талын эгнээнд сууж буй Гүйцэтгэх удирдлагын багийг төлөөлж ирсэн гишүүдэд талархал илэрхийлье. Та бүхний ард ажиллаж буй баялаг бүтээгч ажилтнууддаа мөн талархал илэрхийлмээр байна. Та бүхний хичээл зүтгэл, уйгагүй хөдөлмөрийн дүнд бид ийм үр дүнд хүрч байна гэдгийг аль аль талдаа цохон тэмдэглэж, нөгөө талдаа үүнийгээ хөрөнгө оруулагч нартаа мөн ойлгуулах нь миний хувьд ихэд чухал байгаа гэдгийг уламжилмаар байна.

2024 оны цаашдын зорилго, зорилтууд ба баримталж буй стратегийн талаар Ариунаа захирал дэлгэрэнгүй тайлбарласан. Гэхдээ эндээс бас нэг зүйлийг онцолмоор байна. Олон улсын зах зээлд маш их зардалтайгаар, маш их хүч чармайлт гаргасны эцэст байршсан билээ. Одоо бид дараагийн шатны үйл ажиллагаа руугаа орохоос өөр аргагүй байдалд хүрч байна. Төвлөрөх, гүн нэвтрэх, чанарын өндөр түвшинд ажиллах, үүнийгээ дагаад үнэ цэнээ өсгөх ийм сорилт бидний өмнө ирээд байгаа. Энэ нь мэдээж ERP системийн тусламжтайгаар дажгүй сайхан явах болов уу гэсэн хүлээлттэй байна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Үргэлжлүүлээд ТУЗ-ийн 2023 оны ажлын тайланг танилцуулах хүндтэй үүрэг мөн надад оноогдсон байгаа.

4.4 ТУЗ-ийн 2023 оны ажлын тайланг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь 9 гишүүнтэйгээр 2023 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаар сонгогдсон байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн эхний хурлаар миний бие ТУЗ-ийн даргын хариуцлагатай ажлыг хашихаар сонгогдсон. Мөн ажлаа танилцуулахад бид хамтарч ажиллахад ямар зарчим баримталдаг, яагаад үүнийг их чухал гэж үздэг талаар богино хэмжээний тайлбар хийх нь зүйтэй гэж бодож байна. Сайн засаглалын зарчим гэж бид их ярьдаг, энэ нь монгол хэлэнд их хөндий хөрвүүлэгдээд байдаг. Сайн засаглал гэдгийг би хувьдаа хамтын удирдлага гэж ойлгодог. Хамтаараа компаниа засч сайжруулах, хамтаараа удирдах гэсэн зарчим дээр бид тулгуурлаж ажиллаж байгаа. Сайн засаглалын үндсэн зарчмуудыг эхлээд та бүхэнд танилцуулъя.

1. Шударга тайлагнал явагдах ёстой.
2. Мэдээллийн ил тод байдлаар, бүх оролцогч талууд, ялангуяа хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийг хангах ёстой.
3. Хууль дүрэм журмын нийцлийг бүх талаар баримтлан ажиллах буюу баталсан томъёолсон байгаа бодлогын бичиг баримтынхаа хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг байх нь бидний хувьд нэн чухал.
4. Бүх оролцогч талуудын оролцоог хангах замаар шийдвэрээ гаргадаг байх буюу оролцогч талуудын хэрэгцээ сонирхол аль түвшинд байгаа вэ гэдгийг мэдрэх нь маш чухал. Үүний ард маш хариуцлагатай хамтын ажиллагаа явж байгаа.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгон томилж байгаа. ТУЗ маань нийт 9 гишүүнтэй, үүнээс 4 хараат бус, 5 ердийн гишүүн байдаг. Бид бүгдийн үндсэн үйл ажиллагаа бол ТУЗ-ийн хурал мөн үндсэн чиг үүргийнхээ дагуу ерөнхий удирдлагаар хангах ажлаа Нэр дэвшүүлэх хороо, Цалин урамшууллын хороо, Эрсдэл аудитын хороо хэмээх 3 дэд хороогоор дамжуулан хэрэгжүүлсэн байгаа. Дэргэдээ бид 2 гишүүнтэй ТУЗ-ийн ажлын албатай, энэ нь хурал зохион байгуулагдаагүй үед гишүүдийг мэдээллээр хангах, оролцогч талуудын асуултад хариу өгөх болон өдөр тутмын үйл ажиллагааг хариуцсан чухал чиг үүрэгтэй ажлын алба ажиллаж байдаг. Мөн Эрсдэл аудитын хорооны чиг үүргийн удирдлага доор Дотоод аудитын хэлтэс ажиллаж байгаа.

Шударга, ил тод тайлагналын хүрээнд, бид санхүүгийн үр дүнгээ жил бүр гадаадын, хараат бус аудитын байгууллагаар баталгаажуулан явж байгаа. Тус байгууллагыг сонгох ба хамтран ажиллах нь ТУЗ-ийн үндсэн үйл ажиллагааны нэг байдаг. Ерөнхий зарчмыг та бүхэнд танилцууллаа. Өнгөрсөн жилийн ажлын тайлангаа танилцуулъя.

ТУЗ-ийн ажлын тайлан:

Говь ХК-ийн ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороод нь 2023 онд нийт 14 ээлжит хурал болон 11 ээлжит бус хурал зохион байгуулж гишүүд идэвх санаачилгатай ажиллан нийт 114 асуудлыг хэлэлцэн, 90 шийдвэр гаргаж, 49 тогтоол баталсан бөгөөд чиг үүргийнхээ хүрээнд удирдлагуудад 47 санал зөвлөмж, 37 үүрэг даалгавруудыг өгч, хэрэгжилт дээр нь хяналт тавьж анхаарч ажиллав.

ТУЗ-ийн шийдвэр болон удирдлагуудад өгсөн үүрэг даалгаврын биелэлт 100% хэрэгжилттэй байв. Энэ нь ТУЗ ба Гүйцэтгэх удирдлагын багийн хамтын ажиллагаа нэлээдгүй сайн байгаагийн нэгэн илрэл юм болов уу гэж бодож байна.

Онцлох ажлууд:

- Шинээр дараах бодлого журмуудыг баталсан. Үүнд: Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөр, Оролцогч талуудын хамтын ажиллагааны удирдлагын төлөвлөгөө, Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам, Цалин урамшууллын бодлого
- Хувьцаа эзэмшигч нарын үйлдвэртэй танилцах аялал зохион байгуулж эхэлсэн. Хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөрийн хүрээнд 2 удаа үйлдвэртэй танилцах аяллыг зохион байгуулан хувьцаа эзэмшигч нарыг компанийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн процесстэй биечлэн танилцах боломжийг бүрдүүлэв.
- Компанийн соёлын хүрээнд анхааран ажилласан буюу ТУЗ-ийн зүгээс компанийн хэмжээнд хэрэгжүүлж буй Компанийн соёлыг сайжруулахтай холбоотой арга хэмжээг дэмжин, шаардлагатай төсөв хөрөнгийг баталж, ажлын байрны тав тухтай орчныг бүрдүүлэх, цалинг үе шаттай нэмэгдүүлэх дээр анхаарч ажиллав.

Хороодын ажлын тайлан:

Нэр дэвшүүлэх хороо

Хорооны даргаар хараат бус гишүүн Д.Хүрэлбаатар, гишүүдээр хараат бус гишүүн Д.Гэрэлмаа ба ердийн гишүүн Ц.Оргилболд нар ажилласан.

Хорооны онцлох ажлууд:

- Эрх бүхий албан тушаалтнуудын залгамж халааны бодлогыг боловсруулан ТУЗ-өөр батлуулав.
- Гүйцэтгэх захиралтай байгуулах Менежментийн гэрээний нөхцөлийг шинэчлэн ТУЗ-ийн хурлаар гэрээний загварыг батлуулж, Гүйцэтгэх захиралтай гэрээг шинэчлэн байгуулав.
- 2023 оны ТУЗ-ийн өөрийн үнэлгээ болон ТУЗ-ийн гишүүний өөрийн үнэлгээг хийв. Энэ нь Монголын хувьцаат компаниудын хувьд харьцангуй содон үзэгдэл гэж би судлаач хүний хувьд үздэг. Бид бүгд өөрийн үйл ажиллагааг жил бүр үнэлж байгаа, энэхүү үнэлгээний үр дүнгээр ТУЗ-ийн үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, олон улсын шинэ зарчим ба шинэ стандартууд ба тайлагналын шинэ үзүүлэлтүүдийг нэгтгэн ажиллахын тулд тасралтгүй үнэлгээгээ хийсээр байгаа.
- Ёс суртахуунлаг уур амьсгалыг бүрдүүлэх үүднээс Ёс зүйн дүрмээ шинэчлэн, шүгэл үлээх бодлогын 2 дах сайжруулалтыг хийгээд явж байна. Компанийн шүгэл үлээх системээр ЭБАТ-уудтай холбоотой ирсэн мэдээллийг тухай бүр шийдвэрлэн холбогдох удирдлагуудад санал зөвлөмж, үүрэг даалгавруудыг өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллав.
- 2024 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх нэр дэвшигчдийн нэрсийг тодорхойлов.

Цалин урамшууллын хороо

Хорооны даргаар хараат бус гишүүн Д.Хүрэлбаатар, гишүүдээр хараат бус гишүүн А.Жаргалмаа, хараат бус гишүүн Такэши Камбэ ба ердийн гишүүн Б.Амарсайхан нар ажилласан.

Хорооны онцлох ажлууд:

- ТУЗ-ийн гишүүдийн цалин, хангамж, урамшууллын зарчмыг тодорхойлов. Учир нь олон улсын засаглалын сайн зарчмууд жилээс жилд шинэчлэгдэж байдаг. Мөн ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын асуудал нь олон улсад төдийгүй Монголд ч мөн яригддаг асуудлуудын нэг байдаг тул бид зарчмаа тогтоож тодорхой болгох чиглэл баримталсан.
- Байгууллагын соёлын судалгаа, ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааны үр дүн болон түүнийг сайжруулах чиглэлээр хийгдсэн ажлын үр дүнтэй танилцан санал зөвлөмжийг өгч ажиллав.
- Компанийн 2023 оны цалин урамшууллын гүйцэтгэлд хяналт тавьж, 2024 оны цалин урамшууллын төсвийг хэлэлцэн, ТУЗ-өөр батлуулав.
- Компанийн Цалин, урамшууллын бодлогыг шинэчлэх төслийг хэлэлцэн ТУЗ-өөр батлуулав.
- ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг өөрчлөх асуудлыг хэлэлцэн 2024 оны хувьцаа эзэмшигчдийн хурлаар батлуулах санал боловсруулав.

Эрсдэл аудитын хорооны ажлын тайланг тус хорооны дарга, хараат бус гишүүн, хатагтай А.Жаргалмаа танилцуулах тул тайзнаа урьж байна.

Эрсдэл, аудитын хороо

ТУЗ-ийн гишүүн А.Жаргалмаа: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Миний бие Эрсдэл, аудитын хорооны даргаар ажилладаг. Та бүхэнд хорооны ажлын тайланг танилцуулъя.

Хорооны бүтцийн хувьд даргаар хараат бус гишүүн А.Жаргалмаа миний бие, гишүүдээр хараат бус гишүүн Д.Гэрэлмаа ба ердийн гишүүн Д.Хулан нар ажилласан.

Хорооны онцлох ажлууд:

- Компанийн дотоод хяналт, комплаенс, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах чиг үүргийн хүрээнд Дотоод аудитын хэлтсийн ажлын тайлантай улирал бүр, Эрсдэлийн удирдлагын багийн ажлын тайлантай хагас жил тутам, Комплаенсын удирдлага, үйл ажиллагааны тайлантай 1 удаа танилцаж удирдамжаар ханган ажиллав.
- “Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журам”-д санал оруулан ТУЗ-ийн хурлаар батлуулсан бөгөөд компанийн сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавьж ажиллав.
- “Эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх журам”, “Бизнесийн тасралтгүй үйл ажиллагааны журам”-ыг шинэчлэх төслийг хэлэлцэн, санал зөвлөмжийг өгч Гүйцэтгэх захирлын тушаалаар батлуулав.
- 2023 оны хөндлөнгийн аудиторын сонгон шалгаруулалтад хараат бус байдлын шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг хийж, санал өгч оролцон ТУЗ-ийн хурлаар сонгов.

2023 онд холбоотой талуудтай хийсэн гүйлгээ /Таван Богд Групп/:

Говь ХК нь 2023 онд холбоотой талын санхүүжилтийн зардалд 8.6 тэрбум төгрөг төлсөн нь нийт санхүүжилтийн зардлын 28% эзэлж байна.

Холбоотой талаас авсан санхүүжилтийн зардлын дундаж төгрөгийн хүү нь 16.1%, ам.долларын 7.8% байна. Мөн онцолж хэлэхэд холбоотой тал нь олгосон санхүүжилтэд санхүүгийн харьцаа болон барьцаа хөрөнгө шаарддаггүй.

Говь ХК нь 2023 онд холбоотой талаас авсан худалдан авалтын дүн 3.0 тэрбум төгрөг буюу нийт худалдан авалтын 3.0%, дотоодын худалдан авалтын 3.8%-ийг эзэлж байна.

Бүх холбоотой талын гүйлгээ нь Говь ХК-ийн Худалдан авалтын бодлого, холбогдох журмын дагуу үнийн харьцуулалт судалгааг хийн, сонгон шалгаруулалтын хороогоор орсны үндсэн дээр зах зээлийн үнээр хийгдсэн бөгөөд харилцан давуу байдлыг олгоогүй болно.

Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт

Манай компанийн хувьд хагас жил тутам Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийг үнэлж, хууль дүрмийн хэрэгжилт ямар байгааг дүгнэж явдаг. 2023 оны эцсийн байдлаар Санхүүгийн зохицуулах хорооны хянан баталгаажуулсан үнэлгээг та бүхэнд танилцуулж байна. Нийт 9 үзүүлэлтээр үнэлгээнүүд гарсан байгаа. Үүнд:

1. ТУЗ-ийн бүтэц, зохион байгуулалт - 91.7%
2. ТУЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг – 90.0%
3. Тайлагнал, мэдээллийн ил тод, байдал - 100%
4. Аудит, хяналтын тогтолцоо- 100%
5. Эрсдэлийн удирдлага - 100%
6. Эрх бүхий албан тушаалтны цалин урамшуулал - 100%
7. Оролцогч талуудын эрх ашиг - 100%
8. Компанийн соёл - 100%
9. Хувьцаа эзэмшигчдийн эрх- 100%

Нэгдсэн дүнгээрээ Говь ХК-ийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээ нь 2023 оны эцсээр 97.2% буюу засаглал хэвийн, эрсдэлгүй гэж Санхүүгийн зохицуулах хорооноос үнэлэгдсэн байна. Энэхүү үзүүлэлтээрээ бид Монгол улс дахь нээлттэй хувьцаат компаниуд дундаас эхний байранд үнэлэгдсэн. Анхаарал тавьсанд баярлалаа.

Хөтлөгч 3.Отгонжаргал: Маш их баярлалаа. ТУЗ-ийн дарга, хатагтай Д.Гэрэлмаа таныг ахин тайзнаа урья.

4.5 ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төслийг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Одоо дараагийн 5-р асуудал болох ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэх төслийг танилцуулъя. Энэ асуудал дээр та бүхний саналыг авна.

Манай ТУЗ-ийн гишүүдийн цалин хамгийн сүүлд 2023 оны 4 сарын 20-ны өдрөөр батлагдсан байдаг. Одоогийн байдлаар ТУЗ-ийн гишүүд дараах байдлаар цалин авч байна.

Одоогийн цалингийн бүтэц:

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн бүтэц		Цалин /төгрөг/
Тогтмол цалин	Үндсэн	1,400,000
	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	1,000,000
	Хорооны даргын нэмэгдэл	400,000
Оролцоонд үндэслэсэн цалин	Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	650,000

Хурлын давтамж: /Нэг гишүүн жилд 9-11 хуралд оролцдог/

Хурлууд	Хурлын давтамж
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Жилд 1 удаа
ТУЗ-ийн ээлжит хурал	2 сар тутам буюу жилд 6 удаа
Эрсдэл, аудитын хорооны ээлжит хурал	Улирал тутам буюу жилд 4 удаа
Нэр дэвшүүлэх хорооны ээлжит хурал	Хагас жил тутам буюу жилд 2 удаа
Цалин, урамшууллын хорооны ээлжит хурал	Хагас жил тутам буюу жилд 2 удаа

2024 оны 1-р сард Цалин, урамшууллын хорооны хурлаар хэлэлцэн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын зарчмыг дараах байдлаар тодорхойлсон.

- ТУЗ-ийн гишүүд нь компанийн санхүү, үр дүнгээс хамаарсан аливаа урамшуулал авахгүй.

- ТУЗ-ийн хараат бус гишүүдийн оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагыг үнэлэх зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг ердийн гишүүдийнхээс өндөр байлгана гэж заасан. Учир нь хараат бус гишүүд маань жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ эрх ашгийг төлөөлж байдаг, илүү хариуцлагатай ачаалалтай ажилладаг, мөн хараат бус гишүүдийнхээ мэдлэг ур чадварыг тусгайлан үнэлэх нь зүйтэй гэж үзсэн.
- Мөн компанийн Менежмент багт ажилладаг ТУЗ-ийн ердийн гишүүд нь ТУЗ-ийн гишүүний хувьд аливаа хангамжийг давхар авахгүй гэсэн 3 зарчмыг тодорхойлсон.

Дээрх зарчмын дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүдийнхээ оролцоог нэмэгдүүлэх, хариуцлагатай байлгах, илүү санаачилгатай байлгах зорилгоор хараат бус гишүүдийн үндсэн цалинг нэмэгдүүлэх саналыг оруулж байна. Бусад цалингийн хэмжээнд өөрчлөлт оруулаагүй.

ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох санал:

№	ТУЗ-ийн гишүүдийн цалингийн бүтэц			Одоогийн цалин	Шинэчлэх төсөл	Өөрчлөлт %
1	Тогтмол цалин	Үндсэн цалин	Ердийн гишүүний үндсэн цалин	1,400,000	1,400,000	-
			Хараат бус гишүүний үндсэн цалин	1,400,000	2,800,000	100%
		Нэмэгдэл цалин	ТУЗ-ийн даргын нэмэгдэл	1,000,000	1,000,000	-
			Хорооны даргын нэмэгдэл	400,000	400,000	-
2	Оролцооны цалин		Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн хурал, ТУЗ-ийн дэргэдэх хороодын хуралд оролцсон тоогоор	650,000	650,000	-

4.6 ТУЗ-ийн 2023 оны цалингийн төсвийг танилцуулах

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа танилцуулав.

Агуулга	2023 он			2024 он		
	Төсөв	Гүйцэтгэл	Гүйцэтгэл %	Төсөв*	2024Т/2023Т өсөлт	Өөрчлөлт %
Тогтмол цалин	161,200,000	161,200,000	100%	211,200,000	50,000,000	31%
Оролцооны цалин	41,800,000	37,200,000	89%	50,700,000	8,900,000	21%
НДШ	30,450,000	25,485,000	84%	30,118,500	(331,500)	-1%
Нийт цалин	233,450,000	223,885,000	96%	292,018,500	58,568,500	25%

Хөтлөгч 3.Отгонжаргал: ТУЗ-ийн дарга, хатагтай Д.Гэрэлмаа танд баярлалаа. Дараагийн асуудлыг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ таныг ахин тайзнаа урья.

4.7 ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулах

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ: Говь ХК-ийн дүрмийн 6.2.3-д ТУЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байхаар заасан. Говь ХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч Таван Богд Холдингс ХХК-аас 2024 оны 2-р сарын 29-ний өдөр ТУЗ-ийн ердийн гишүүнд нэр дэвшигчид санал оруулах тухай албан хүсэлт ирүүлсэн. Нэр дэвшүүлэх хорооны 2024 оны 3-р сарын 19-ний өдрийн №02 тоот тогтоолоор 2024 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд нэр дэвшигчдийг тодорхойлсон.

/Хувьцаа эзэмшигчдийн хурлын материалын 52-оос 57-р хуудас дахь нэр дэвшигчдийн танилцуулгыг танилцуулав./

Хөтлөгч 3.Отгонжаргал: ТУЗ- ийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ танд баярлалаа. Ийнхүү асуулт, хариултын хэсэг эхэлж байна. Хүн тус бүр 2 минутад багтаан асуулт асуух боломжтой. Асуулт асуухыг хүсвэл та гараа өргөнө үү. Манай зохион байгуулагчид танд микрофон аваачиж өгөх болно. Та бүхэн чөлөөтэй асуултаа асууна уу.

5. АСУУЛТ ХАРИУЛТ

/Нийт 20 минут/

АСУУЛТ 1.

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Би асуултаас илүү хэлэх зүйлээ хэлье гэж бодлоо. Говь ХК маань 2023 онд сайн ажилласан юм байна. Түүхэндээ байгаагүй 255 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн гэдэг нь уул уурхайн бус хөнгөн үйлдвэрийн салбартаа маш өндөр борлуулалт юм. Үүнийг бол хувьцаа эзэмшигчийн хувьд сайшааж хэлэхийг хүсэж байна. Одоо хэлэх нэг зүйл гэвэл ер нь бизнесийн байгууллагын гол зорилго бол ашиг олох шүү дээ. Тэгэхээр Говь ХК маань сүүлийн 6 жилд ногдол ашиг хуваарилсангүй. Үүнд жаахан сэтгэл дундуур байдаг. Яах вэ, КОВИД-ын үеийг бол ойлгож байна. Тэр үе бол бүх л компаниудад хүнд туссан. 2022 оныг бид нар ойлгож байна. 2023 онд борлуулалт ийм өндөр байхад ногдол ашиг тараахгүй, дээрээс нь алдагдалтай ажилласан учраас Гүйцэтгэх удирдлагын багийг тултал нь хангалттай ажилсан гэдэг ТУЗ-ийн дүгнэлттэй би санал нийлэхгүй байна. Илүү их бололцоо байсан байх, тэрийгээ шахаж ажиллаж чадсангүй юу гээд сэтгэл дундуур байна. Гэхдээ Монголдоо хөнгөн үйлдвэрийнхээ салбарыг хөгжүүлээд, эцсийн бүтээгдэхүүн хийнэ гэдэг бол их хүндрэлтэй байдаг. Ажиллах хүч хэр байдаг билээ гэдгийг энэ салбарт 40 гаруй жил ажиллаж буй хүний хувьд би ойлгоно. Би саяхан ноосны салбарын Улаанбаатар хивс ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хуралд нь оролцсон. 2022, 2023 онуудад ногдол ашиг тарааж боломжийн ажилласан. Тэгэхээр ноолуурын салбар маань арай өндөр үнэтэй зарах гэх мэтээр ноосны салбараас нэг шат ахиу явах боломж байдаг. Энийг хэлье гэж бодлоо. Та бүхэн гадаад зах зээл дээрээ маркетингийн зардал дээрээ их мөнгө зарсан юм байна гэдгийг бас ойлголоо. Энэ нь бас нөлөөлсөн болов уу гэж бодож байна.

Би өнгөрсөн жилийн хурал дээр салбарын мэргэжлийн хүний хувьд бас нэгэн асуудал дурдаж байсан. Манай Говь ХК-ийн хувьд нийт бүтээгдэхүүний ээрч буй нарийн утсыг 30 хувь хүртэл болгоосой гэж байнга хүсэж явдаг. Одоо бид ерөөсөө жаахан чанар муутай бүтээгдэхүүн хийгээд маш өндөр үнэтэй маркетинг хийвэл жинхэнэ алдагдал болно. Тэгэхээр бүтээгдэхүүн хөгжүүлэлт болон бүтээгдэхүүний чанарыг сайжруулах талууд дээр маш их хөрөнгө оруулалт хийж, онцгой анхаарах хэрэгтэй гэж би боддог. Хятадын томоохон үйлдвэрүүдээр би бас очиж үзсэн. Ер нь ноолууран бүтээгдэхүүнүүдийг их өндөр үнэтэйгээр зардаг. Үндсэн 26 номероос гадна 60, 100 болон 80 номерын утаснуудыг л хийгээд байна шүү дээ. 26 маань яадаг вэ гэхээр шааригтай гардаг, бөөсөрдөг гээд нэр муутай. Солонгосчууд зөндөө худалдан авалт хийсэн гэж байна. Сайн байна. Хойтон жил Говийн бүтээгдэхүүнийг нэг жил өмсөөд бөөстсөн гэх вий. Үүнийг арилгахын тулд бид ерөөсөө нарийн утас л хийх хэрэгтэй. Өнгөрсөн жил энэ тал дээр ажиллана гэж байсан бас юу болсон юм болоо гэдгийг тодруулж асуумаар байна.

Ноос ноолуурын салбарт НӨАТ-ын тухай хуулийн 11.1-ийг манай холбооноос санаачилж оруулаад Говь ХК маань ч мөн хамрагдаад явж байгаа. Өнгөрсөн жил НӨАТ-ын хасалтаар 4 тэрбум төгрөг хэмнэсэн гэж хэлж байсан. Энэ жил хэдийг хэмнэсэн бэ? Түүхий эд худалдаж авах зэрэгт та бүхэнд нэмэр болж байна уу гэдгийг асуумаар байна. Мөн та бүхэндээ ажлын амжилт хүсье ээ.

Хариулт:

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Үр дүн ба ногдол ашгийн талаар жижиг тайлбар хийх шаардлагатай болов уу гэж бодож байна. Мэдээж бид бизнес төлөвлөгөөгөө гаргахдаа аль болох өөдрөгөөр хардаг. Гэвч манай улсын хувьд бид нар цөөхөн, ердөө 3.5 сая хүн амтай.

Мөн аж үйлдвэржилтийг хөгжүүлээд удаагүй байгаа, манай Говь ХК-ийн хувьд 42 жилийн түүхтэй. Ялангуяа олон улсын тавцанд гарч ажиллахад бидэнд туршлага мэдлэг, ялангуяа маркетингийн мэдлэг чадвар хамгийн ярвигтай асуудал байлаа. Маш их хэмжээний зардал гаргасан. Нөгөө талдаа үйлдвэр рүүгээ, мөн цахим талбар руугаа хөрөнгө оруулалт хийхээс өөр аргагүй байдалтай ажилласан гэдгийг хэлмээр байна. Уг нь бол бид алдагдалгүй ажиллаж та бүхэнд ногдол ашиг хуваарилах чин хүсэл бол байдаг. Гэвч нөгөө талдаа жижиг тайлбар хэлэхэд, ганцхан ногдол ашиг тарааснаар хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг хэрэгжих нь нэг талдаа асуудалтай. Ногдол ашгийг сонирхож байгааг бас ойлгож байна. Нөгөө талдаа компанийн зах зээлийн үнэлгээ өсөж байх нь маш чухал байдаг. Ханш маань тогтвортой байх нь өөрөө бас чухал. Жижиг хувьцаа эзэмшигчдийн маань хувьд бол ногдол ашгаас илүүтэйгээр ханш тогтвортой байх, ханш өсдөг байх асуудал бас нэн чухал байдаг гэдгийг хэлмээр байна. Та бүхэн үүнийг мөн анхааралдаа аваарай. Гэхдээ бид өөрсдийгөө өмгөөлөөгүй ээ. Монгол Улсынхаа нэрийг дэлхийд гаргах зорилготойгоор өндөр зардалтай маркетинг хийж, бүтээгдэхүүнээ сайжруулж, олон улсын тавцанд өрсөлдөх чадвартай болох гээд хичээн ажиллаж байгаа гэдгийг мөн хэлмээр байна. Нарийн утас, түүхий эдтэй холбоотой асуултад Тэргүүн дэд захирал Б.Энхмандах хариулах болно.

Тэргүүн дэд захирал Б.Энхмандах: Хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэдээ бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Түүхий эдээс эхлээд хариулъя. 2023 оны хувьд Говь ХК нийт 500 орчим тонн түүхий ноолуур худалдаж авсан. Үүнтэй холбоотойгоор 7 тэрбум орчим төгрөгийн НӨАТ-ын хөнгөлөлтийг буцаан авалтаар авсан байна. Хуулийн шинэчлэлтэй холбоотойгоор энэхүү хөнгөлөлтийг авснаар компанийн хувьд зардал буурахад мөн нөлөөлөл үзүүлж байгаа. Нарийн ээрэх утасны хувьд бид тасралтгүй судалгаа хийгээд сайжруулаад явж байгаа. Мэдээж дэлхийн дулаарал болж байгаатай холбоотой бид summer cashmere зэрэг коллекц гаргаад, нарийн сүлжмэл бараа бүтээгдэхүүн хэрхэн хийх тал дээр тасралтгүй судалгаа хийж байгаа. Цаашдаа ч мөн үүнийгээ үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ гэж бодож байна. Баярлалаа.

АСУУЛТ 2.

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Сайн байна уу? Өмнөх удаагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар оролцож байсан. Өнөөдөр харахад эдийн засгийн бүх үзүүлэлтүүд бараг бүгд өссөн байна. Тийм болохоор Говь ХК бол илүү сайн ажиллаад явж байгаа гэж товчхон харлаа. Өмнөх удаагийн Хувьцаа эзэмшигчдийн хурлаар мөн 2 санал хэлж байсан. Тэр саналуудыг ерөнхийдөө анхаарч үзсэн гэж би хувьдаа үзэж байна. Яагаад гэвэл би Говь ХК-ийн загварын чиг хандлага ерөөсөө өөрчлөлтгүй байна, орчин үеийн чиг хандлагатай уялдуулахгүй байна гэдэг санал хэлсэн, мөн арга хэмжээ ба үйл ажиллагаанууддаа хувьцаа эзэмшигчдийг хамруулж оролцуулж байгаарай гэдэг саналууд хэлсэн. Энэ саналын дагуу загварын чиг хандлагаа сайжруулж байгаагаа танилцуулсан, мөн шинэ коллекцын загварын арга хэмжээнд урьж хувьцаа эзэмшигчдийг хамруулсан. Олон сайхан загварууд хийсэн байна билээ. Хоёрдугаарт, маркетингийн зардлыг бол бууруулсан байна. Маркетингийн зардал бол компанийн хөгжилд хамгийн их нөлөөтэй. Зар сурталчилгаа, мэдээлэл зэрэг бол компанид их үр ашигтай. Яагаад маркетингийн зардлыг ийм ихээр бууруулж байгаа вэ? гэдэг асуулт байна. Дараагийн асуулт бол, хувьцаа эзэмшигчдийн нөлөө бол компанийн хөгжилд их байдаг. Аль болох олон хувьцаа эзэмшигчидтэй бол компани ирээдүйд хөгждөг гэж үздэг. Тэгэхээр яагаад ногдол ашиг өгдөггүй вэ? Цаашдаа хэдэн оноос өгөхийг зорьж байгаа вэ? Одоо банк санхүүгийн салбарт хувьцаа эзэмшигчдийг ногдол ашгаараа маш сайн татаж байна. Миний хувьд маш цөөн тооны хувьцаа эзэмшдэг. Найз нөхөд маань Говь ХК-ийн хувьцаа эзэмшдэг гэхээр ногдол ашиг гэж их өгдөг үү гэж асуудаг. Өгдөггүй гэхээр хүмүүс их гайхдаг. Мөн дэлхийд нэг номерт гарна гэж шинэ Гүйцэтгэх захирал хэлж байсан. Тиймээс ногдол ашиг хэзээ өгч хувьцаа эзэмшигч нартаа анхаарах вэ? Бас эрчимжсэн мал аж ахуйд анхаардаг хүмүүсийг УИХ-д дэвшүүлнэ гээд байгаа. Тэгэхээр манай орны бэлчээрт багтахгүй байгаа тул малын тоо

толгойг бууруулна гэж байгаа. Тийм учраас малын тоо толгой цөөрөөд ирэхээр ноолуураа яаж бэлтгэх вэ? Өнөөдөр Эмээлт зах дээр ноолуурын үнэ бараг 200,000 төгрөг хүрсэн. Ер нь яаж ноолуураа татаж авдаг вэ? Дотоодоос ноолуурын хэдэн хувийг авдаг вэ? Цаашид ноолуураа ч авч чадахгүй гадаад дотоодод зарах юм уу гэсэн ойлголт байна. Тэгэхээр ноолуураа ихийг авах боломжийг яаж судлах вэ? Эдгээр асуултуудад хариулна уу.

Хариулт:

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Олон чухал асуултууд асуулаа. Маркетингийн зардал ба ногдол ашигтай холбоотой асуултад би жижиг тайлбар өгье. Бид ашигтай ажиллаад эхэлбэл шууд л ногдол ашиг тараана. Одоо бид 6.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байгаа. Ногдол ашгийн бодлого дээрээ 2 нөхцөл тавьсан учраас ирээдүйд тогтвортой үйлдвэрлэлээ явуулахад хангалттай байх хоёр нөхцөлөө хангаагүй тул ногдол ашиг тараах нөхцөл бүрдээгүй гэдгийг түрүүн та бүхэнд мөн тайлбарласан. Гэхдээ бидний чин хүсэл бол аль болох та бүхний оруулсан хөрөнгийн өгөөжийг аль болох өндөр байлгахаар хичээж байна. Гэвч миний бодлоор давагдашгүй ийм нөхцөл байдал ирээд байна. Манай Говь ХК-ийн үйлдвэр бол мэдээж олон улсын томоохон үйлдвэрүүдтэй харьцуулбал арай жижиг байгаа. Гэхдээ Монголдоо бид бүтэн үйлдвэрлэлээ явуулж, эхнээс нь эцсийн бүтээгдэхүүн хүртэлх гинжин хэлхээг өөрсдөө хариуцаад явж байгаа. Энэ том тогтолцоо нь нэг цочролд орохоороо амархан сэргэж засагдахад тодорхой хэмжээний цаг хугацаа шаарддаг юм байна гэдгийг та бүхэнд бас хэлье. Үүний ард бид байдаг чадлаараа хичээж байгаа. Гэхдээ үүнийг засахгүй орхиод маргаашаа бодохгүй байж болохгүй. Маргаашдаа хөрөнгө оруулалт хийж байж маргаашийн орлогоо бид олно. Ер нь дараа жилийн бидний төсөөллөөр бол ашигтай ажиллах төсөөлөлтэй явж байгаа тул дараа жилээс эхлэн ногдол ашиг хуваарилах болов уу гэсэн бодол надад байна. Бусад асуултад Тэргүүн дэд захирал Б.Энхмандах хариулна.

Тэргүүн дэд захирал Б.Энхмандах: Маркетингийн зардал дээр нэмж хэлэхэд, түрүүн танилцуулсанчлан гадаад зах зээл дээрх маркетингийн зардлыг бууруулж байгаа. Мөн удирдлагын зардлыг бууруулж байгаа. Сүүлийн жилүүдэд 25-30 тэрбум төгрөгийг зарцуулсан бол ирэх онд 9 тэрбум төгрөгийг маркетингд зарцуулах байгаа. Яагаад ингэж бууруулж байна вэ гэвэл бүртгэлтэй харилцагчийн тоо нь 600 мянгад хүрсэн. Бид дотоодод ойролцоогоор 270 мянган харилцагч нартай ажилладаг тул одоо байгаа бүртгэлтэй харилцагч нартаа анхаараад явбал пропорцоор нь бодоход 9 тэрбум төгрөгийн маркетингийн зардлаар 27 тэрбум төгрөгийн борлуулалт хийх хангалттай боломжтой гэж үзэж байна. Мэдээж 9.3 тэрбум төгрөгөөрөө илүү брэндээ танигдуулах тал руу маркетингаа хийгээд явна гэж харж байна.

Түүхий эдийн бэлтгэл дээр өмнөх жил бид 500 тонн ноолуур бэлтгэсэн байгаа. Энэ нийтдээ Монгол Улсын ноолуурын 5%-ийг эзэлж байгаа. Дэлхийн зах зээлд гарч буй тул борлуулах бүтээгдэхүүний тоо ширхэг ч цаашид нэмэгдээд явна. Тэгэхээр бид ойрын 5 жилдээ үүнийг 20%, цаашдаа 50% хүргэх зорилготой. Үүний төлөө мөн хичээгээд ажиллаж байна. Мөн ноолуурын бэлтгэлийн талаар асуусан байгаа. 3 сараас эхлэн ноолуур бэлэн болж эхэлдэг. Бид эхлээд Хэнтий, Сүхбаатар зэрэг зүүн аймгуудаас ноолуураа авч эхэлдэг. Дараа нь Хөвсгөл, Баянхонгор, Увс зэрэг баруун аймгуудаас авдаг. Мөн хоршоо болон хувь малчдаас бэлтгэлээ хийдэг байгаа. Баярлалаа.

САНАЛ 1.

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Танай компани ТОП-20 компанид ордог. Өнөөдөр би Төрийн банк болон Хас банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож ирээд танай хуралд суухад бүртгэлээ хаасан тул саналаа өгч чадахгүй байна. ТОП-20 компанийн хувьд хурлын өдрөө бусад том компани болон банктай, давхардахгүй байхад анхаарах боломжтой юу? Мөн цахимаар санал авдаг болмоор байна.

Хариулт:

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Таныг саналыг хүлээж авлаа. Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, зохион байгуулах нь өөрөө тодорхой зохицуулалттай байдаг. Бусад компаниудын хурлын өдөр зарлагдахыг хүлээвэл бид хуулийн хугацаандаа амжихгүй болох эрсдэл байдгийг та ба ойлгож байгаа байх. Энэ зохицуулалтын талаар ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ тайлбар өгнө.

ТУЗ-ийн дарга М.Сэлэнгэ: Компанийн тухай хуульд заасны дагуу нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал нь 4 сарын 30-ний өдрийн дотор хуралдах ёстой байгаа. Бид ТУЗ-өөрөө хэлэлцээд хурлын өдрөө товлосон. Энэ нь компанийн дотоод үйл ажиллагаа ба хөндлөнгийн аудиторын дүгнэлт гарах хугацаа гэх мэт олон зүйлээс хамаарч байгаа. Бид бүхэн хамгийн боломжтой хугацаагаараа зохион байгуулж буй нь 4 сарын 29-ний өдөр байгаа.

САНАЛ 2.

Нэрээ хэлээгүй хувьцаа эзэмшигч: Та нар ногдол ашиг өгөхгүй байгаа, тэгээд өөрсдийн цалингаа нэмүүлж авах гэж байна. Танай хувьцаа эзэмшигч байх ямар хэрэг байна? Хувьцаагаа шилжүүлж болох уу? Та нар юу хийгээд байгаа юм бэ? Ашиггүй ажиллаж байгаа мөртөө зөвхөн ТУЗ-өө шагнах юм яваад байгаа юм уу? Тэр ашиг чинь хаана байна? Зөвхөн ТУЗ нь аваад байгаа юм уу? Яагаад ногдол ашиг өгөхгүй байгаа юм?

Хариулт:

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Таныг саналыг хүлээж авлаа. Та хувьцаагаа зарж шилжүүлэх бүрэн боломжтой. Мөн бид түрүүн танилцуулсанчлан ТУЗ-ийн гишүүдийн хувьд компанийн үйл ажиллагаанаас ямар нэгэн урамшуулал авахгүй байх гэдэг зарчмыг баталсан байгаа. Яагаад алдагдалтай ажилласан болон ногдол ашиг тараагаагүй талаар түрүүн тайлбарууд хийсэн байгаа. Нэмэлт тайлбар хэрэгтэй байгаа учраас манай санхүүгийн тайланд аудит хийсэн хараат бус аудитын компани KPMG-ийн төлөөлөл, ахлах аудитор Д.Чинболдыг хариулна уу хэмээн тайзнаа урьж байна.

KPMG-ийн төлөөлөл, ахлах аудитор Д.Чинболд: Сайн байцгаана уу, би KPMG аудитын компанийг төлөөлж хуралд оролцож байна. Говь ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллүүдийг удирдлагууд бидэнд өгөөд бид аудит хийдэг. Говь ХК нь 6.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан дээр бид аудитын дүгнэлтээ өгсөн. Удирдлагаас бидэнд үнэн зөв мэдээлэл өгч, аудитын стандартын дагуу үндэслэлтэй байна гэж бид үзсэн байгаа. Энэ үндэслэлийн дагуу компани дотооддоо хэлэлцээд ногдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн байна. Аудитын компанийн хувьд бид Говь ХК-ийг эрсдэлийг хэрхэн үнэлсэн даван туулсан тухай дүгнэлтийг өгсөн. Удирдлагаас өгсөн тайлантай холбоотой мэдээллийг би баталгаажуулахгүй. Харин Говь ХК нь 6.8 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь үнэн бодитой тайлагнагдсан гэдгийг баталж байна. Баярлалаа.

Хөтлөгч З.Отгонжаргал: Баярлалаа. Одоо ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ санал өгөх зааварчилгааг танилцуулна.

6. САНАЛ ХУРААЛТ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ санал өгөх зааврыг танилцуулан, санал хураалтыг албан ёсоор нээж нийт санал хураалт нийт 20 минут үргэлжлэв.

7. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ НЭГТГЭХ

Тооллогын комисс саналын хайрцгийг задлан, санал хураалтын дүнг нэгтгэв. Нийт 20 минут үргэлжлэв.

Хөтлөгч 3.Отгонжаргал: Санал хураалтын дүнг танилцуулна уу хэмээн Тооллогын комиссын дарга, хатагтай Н.Сайнзул таныг урьж байна.

8. САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГ ТАНИЛЦУУЛАХ

Тооллогын комиссын дарга Н.Сайнзул танилцуулав.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 67.3, Говь ХК-ийн дүрмийн 6.1.10-6.1.16 заалтыг удирдлага болгон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын санал хураалтын дүнг нэгтгэн тоолсныг үндэслэн ТОГТООХ НЬ:

Нэг. Нийт **88.61** хувийн саналын эрхтэй **691,220,958** ширхэг хувьцааны **697** ширхэг саналын хуудас хураасныг тооцсугай.

Хоёр. 2024 оны 04-р сарын 29-ний өдөр санал хураах хайрцгаар **87.01** хувийн саналын эрхтэй **678,754,652** ширхэг хувьцааны **68** ширхэг саналын хуудас хураасныг дурдсугай.

Гурав. Урьдчилж ирүүлсэн саналын хуудасны хувьд шуудангаар дамжуулж **0.00** хувийн саналын эрхтэй **7,000** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, үнэт цаасны компаниар дамжуулж **1.55** хувийн саналын эрхтэй **12,099,235** ширхэг хувьцааны **1** ширхэг саналын хуудас, компанийн байранд **0.05** хувийн саналын эрхтэй **360,071** ширхэг хувьцааны **627** ширхэг саналын хуудас тус тус урьдчилж ирүүлснийг дурдсугай.

Дөрөв. Нийт саналын хуудаснаас **0.01** хувийн саналын эрхтэй **93,469** ширхэг хувьцааны **50** ширхэг саналын хуудас хүчингүй болсныг дурдсугай.

Тав. Говь ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс өгсөн дүгнэлтийг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Зургаа. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Долоо. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны цалингийн төсвийг батлах тухай асуудлыг хуралд оролцогчдын саналын эрхийн олонхоор буюу **99.99** хувийн саналаар баталсныг мэдэгдсүгэй.

Найм. Говь ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус болон ердийн гишүүдийг сонгох асуудлаар хувьцаа эзэмшигчдийн өгсөн саналыг кумулятив аргаар тоолж, хамгийн олон санал авсан 9 гишүүдийг сонгон томилсныг мэдэгдсүгэй.

Хөтлөгч 3.Отгонжаргал: Сайнзүлдаа баярлалаа. Хурлаас гарах тогтоолын төслийг танилцуулна уу хэмээн ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ таныг урьж байна.

9. ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫГ ТАНИЛЦУУЛАХ

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга М.Сэлэнгэ танилцуулав.

Тооллогын комиссын санал хураалтын үр дүнд үндэслэн хурлаас гарах дараах 4 тогтоолын төслийг танилцуулав.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай
2. ТУЗ-ийн гишүүдийн цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай
3. ТУЗ-ийн 2024 оны цалингийн төсвийг батлах тухай
4. ТУЗ-ийн гишүүдийг сонгон томилох тухай

Хөтлөгч 3.Отгонжаргал: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга, хатагтай М.Сэлэнгэ танд баярлалаа. Ингээд хурлыг хааж үг хэлнэ үү хэмээн ТУЗ-ийн дарга, хатагтай Д.Гэрэлмаа таныг урьж байна.

ХУРЛЫН ХААЛТ

ТУЗ-ийн дарга Д.Гэрэлмаа: Баярлалаа. Хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигч нартаа дахин талархал илэрхийлье. Бид хэлэлцэх 7 асуудлаа амжилттай хэлэлцлээ. Хурлын уур амьсгал нээлттэй, ил тод, ойлгомжтой болсон байх гэж бодож байна. Та бүхний үзэл бодол, байр сууриа илэрхийлэх боломж хувьцаа эзэмшигч нарын хурал дээр үргэлж хангагдаж байх ёстой. Тиймээс бидний зүгээс бас их хичээлээ.

Хурлаас гарсан гол гол шийдвэрүүдийг сая тогтоолоор танилцууллаа. Миний зүгээс дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг товллохдоо бусад хувьцаат компаниудын хурлын хуваарьтай танилцах чухал үүргийг авлаа. Хоёрдугаарт, энэ жил ашигтай ажиллаж ногдол ашиг хуваарилах тал дээр манай Менежментийн баг, ТУЗ-ийн гишүүд ханцуйгаа шамлан ажиллах шаардлагатай тулгарч байгааг өөртөө болон хамт олныхоо өмнөөс гүнээ ухамсарлаж байна гэдгээ хэлмээр байна. Бид хичээж, зүтгэж ажиллая.

Мөн дээрээс нь санал хураалтад нээлттэй оролцох, цахимаар санал өгөх эрхээ эдлэх боломжийг олгох дээр дараа жилийн хурлын зохион байгуулалт дээр анхааръя.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурал ингээд өндөрлөлөө. Хүрэлцэн ирсэн та бүхэндээ маш их баярлалаа.

Хурал 11 цаг 55 минутад өндөрлөв.

Хурлын даргалагч:

ТУЗ-ийн дарга



Д.ГЭРЭЛМАА

Хурлын тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн мэргэжилтэн



Г.ДЭМЧИГСЭЛМАА